



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/391

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.10 дахь заалтууд, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.11.1 дэх заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 35 дугаар тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 15 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс болон орон нутгийн төсвийн орлогын суурь баазыг нэмэгдүүлэх, хууль эрх зүйн талаар олон нийтэд суртачилан таниулах зорилгоор зохион байгуулах "Татвар төлөгчдийн өдрүүд-2025" арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2. Арга хэмжээний зардалд шаардагдах 20.820.000 (Хорин сая найман зуун хорин мянга) төгрөгийг батлагдсан эх үүсвэрээс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат)-д зөвшөөрсүгэй.

3. Батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулах арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, үр дүнг аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хуралд тайлагнахыг аймгийн Татварын газрын дарга (Н.Энхтуяа)-д үүрэг болгосугай.


4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Л.Хаш-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн засаг даргын 2025 оны 07 сарын 04
өдрийн 44 тоот захирамжийн хавсралт



2025 ОНЫ ТАТВАР ТӨЛӨГЧДИЙН ӨДРҮҮДИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

ДД	Зардлын нэр	Тоо хэмжэ э	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Бэлтгэн нийлүүлэгч
1	Аймгийн шилдэг татвар төлөгч ТОП-10	10	465,000	4,650,000	Мастер квалити ХХК
			535,000	5,350,000	ТОП-10 шалгарсан ААН-үүд
2	Анонос 4ш /30м2/	30	14,000	420,000	Мастер квалити ХХК
4	Гарын авлага тараах материал	2800	3,000	8,400,000	Мастер квалити ХХК
		1000	1,500	1,500,000	
5	Зургийн уралдаанд оролцсон сурагчдад талархал	20	25,000	500,000	Мастер квалити ХХК, Аз жаргал
	ДҮН	3860	1043500	20820000	

оОо